

**ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 5 гишүүнээс 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийг нэгтгэн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

Нэг.2022 онд батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлж нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд олгох тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг нарийвчлан зохицуулахаар;

Хоёр.Төрийн үйлчилгээг цахимжуулах зорилтын хүрээнд нэмэлт тэтгэврийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаа болон хөтөлбөр бүртгэхтэй холбоотой баримт бичгийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэх зохицуулалтыг тусгалаа.

Ажлын хэсгээс Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 54 санал, найруулгын шинжтэй 1 санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 1 санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гишүүнчлэлтэй ажилтан, гишүүд өөр байгууллагад шилжсэн тохиолдолд тэтгэврийг шилжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтын талаар болон ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны сард төлөх шимтгэлийн доод хязгаарыг

хөтөлбөрт хамрагдсан ажилтны сард төлөх шимтгэлийн доод хязгаарыг тогтоосон нь сайн дурын даатгалын зарчимтай нийцэж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.


Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нараас өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгтгэн явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



П.АНУЖИН